

ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ТЭГШ ЭРХ, ОРОЛЦООГ ХАНГАХАД ЭРХ ЗҮЙН ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Гамииг судлалын магистрант, Г.Золжаргал

Хураангуй:

Нэгдсэн үндэсний байгууллагаас боловсруулсан эмэгтэйчүүдийн эрх, олон талт оролцооны талаархи гэрээ, конвенци, эрх зүйн болон бусад бодлогын баримт бичгийг боловсруулсан байдал болон охид, эмэгтэйчүүдийн жендерийн тэгш эрхийг хамгаалах, эмэгтэй энхийг сахиулагч нарын ажиллагаанд үүрэг гүйцэтгэх давуу талыг дэлгэрэнгүй авч үзсэн болно.

түлхүүр үг: Эмэгтэйчүүдийн эрх, олон талт оролцоо, гэрээ, бодлогын баримт бичиг

Удиртгал

Нэгдсэн үндэсний байгууллага нь олон улсын хууль, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран ажиллах зорилго бүхий олон улсын байгууллага юм. Нэгдсэн үндэсний байгууллага нь 1945 оны 10-р сарын 24-нд АНУ-ын Калифорни муж улсын Сан-Франциско хотод 51 гишүүн оронтойгоор үндэс сууриа тавьж байжээ. 2022 оны байдлаар 193 орныг эгнээндээ нэгтгээд байна.

Гол байгууллагууд :

Нэгдсэн үндэсний байгууллага нь Ерөнхий чуулган, Аюулгүйн зөвлөл, Эдийн засаг, нийгмийн зөвлөл, Нарийн бичгийн даргын газар, Олон улсын шүүх зэрэг таван үндсэн байгууллагаас бүрдэнэ.

Нэгдсэн үндэсний байгууллагын үйл ажиллагааны үндсэн зорилго нь:

- Олон улсын хэмжээний асуудлыг шийдвэрлэх,
- Энхтайван, аюулгүй байдлыг сахиулах,
- Хүний эрхийг хамгаалах,
- Улс орнуудийг харилцааг зохицуулах,

Тэр дундаа **энхийг сахиулах** нь Нэгдсэн үндэсний байгууллагын хамгийн чухал үүрэг бөгөөд тус байгууллагын дүрмийн 1-р бүлгийн 1-р зүйлд Нэгдсэн үндэсний байгууллагын зорилгын нэгээр тодорхойлогдсон байдаг¹⁵.

Үндсэн хэсэг

¹⁵ <https://mn.wikipedia.org/>

Нэгдсэн үндэсний байгууллагаас эмэгтэйчүүдийн эрх, олон талт оролцооны талаар 1979 онд батлагдсан жендэрийн эрх тэгш байдлыг хангах “Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенци”, 1995 онд батлагдсан “Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө” зэрэг гэрээ, конвенци, эрх зүйн болон бусад бодлогын баримт бичгүүдийг гаргасан байдаг. Эдгээр бодлогын баримт бичгүүдэд эмэгтэйчүүдийн тэгш эрх, оролцооны талаар дараах байдлаар тодорхойлсон байдаг. Үүнд:

1. Эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай конвенци нь эмэгтэйчүүдийн тэгш эрхийн талаарх асуудлыг баталгаажуулсан хамгийн чухал олон улсын гэрээ бөгөөд 1979 онд батлагдаж 1981 оноос хүчин төгөлдөр болсон байна. Энэхүү гэрээнд " жендэрийн эрх тэгш байдлыг хангах асуудлыг дотоодын хууль тогтоомжид тусгах, хуулин дахь бүхий л алагчилсан заалтуудыг хүчингүй болгох, өөрчлөх эмэгтэйчүүдийг алагчлахын эсрэг " зорилготой.

Монгол улсын хувьд эмэгтэйчүүдийг алагчлах үзлийг устгах хорооны 82 дугаар хуралдаанаар буюу 1980 оны долоодугаар сарын 10-ны өдөр гарын үсэг зурж, нэгдэн орсон бөгөөд 1981 оны тавдугаар сарын 14-ний өдөр соёрхон баталсан. Монгол улс 2022 оны 06 дугаар сарын 22-23 ны өдрүүдэд үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хөндлөнгийн оролцооны хяналт шинжилгээ, үнэлгээг хийлгүүлж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 6 зорилт, 59 дэд зорилтын хэрэгжилтийн үнэлгээний дунджаар хөтөлбөрийн зорилгын хэрэгжилтийг нэгтгэн 80.4 хувьтай үнэлсэн талаар, мөн Ажлын алба нь 2017-2021 онд 125 сургалтыг зохион байгуулж, нийт 16500 төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг хамруулснаас, нийт 11000 эмэгтэй, 5500 эрэгтэй албан хаагчдыг сургаж ажилласан талаархи тайланг танилцуулсан байна¹⁶.

2. “ Бээжингийн тунхаглалын үйл ажиллагааны төлөвлөгөө ” конвенц нь: Эмэгтэйчүүдийг жинхэнэ тэгш эрх болон эрх мэдлээр хангах " ядуурал, боловсрол, эрүүл мэнд, хүчирхийлэл, зэвсэгт мөргөлдөөн, эдийн засаг, эрх мэдэл, шийдвэр гаргах, төрийн институцийн механизм, хүний эрх, хэвлэл мэдээлэл, байгаль орчин, охин-хүүхэд гэсэн хорин гурван зорилт арван хоёр тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон баримт бичиг юм.

Мөн Нэгдсэн үндэсний байгууллагын Тогтвортой хөгжлийн зорилтууд бүгд эмэгтэйчүүдийн аж байдлыг дээшлүүлэхэд чиглэж дараах асуудлыг эн тэргүүнд тавьсан байна. Үүнд:

¹⁶ <https://mpress.mn/p/9323>

- Жендэрийн эрх тэгш байдлыг хангах
- Бүх охид эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох;
- Эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, түүний дотор хүний хулгай наймаанд өртөх, бэлгийн болон бусад хэлбэрээр дарлан, мөлжих;
- Шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх,
- Эмэгтэйчүүдийн эрх мэдлийг нэмэгдүүлэх, хүчирхэгжүүлэхийн тулд санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэхэд хувь нэмрээ оруулах, түншлэлийг хөгжүүлэхийн төлөө ажиллаж байна.

Дээрхи эмэгтэйчүүдийн эрх, олон талт оролцооны талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтээс улбаалан дараа дараагын баримт бичгүүд гарч байгааг нэгдсэн үндэсний байгууллагын мянганы хөгжлийн зорилтоос харж болно.

Нэгдсэн үндэсний байгууллагын Мянганы хөгжлийн зорилтууд нь ядуурлыг бууруулах тодорхой зорилтууд, тэр дундаа боловсрол, хөдөлмөр эрхлэлт болон төлөөллийн хэлбэрүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай зорилтуудыг тусгасан.

Нэгдсэн үндэсний байгууллагын тогтвортой хөгжлийн зорилгын 5 дугаар зорилтын хүрээнд эмэгтэйчүүдийн эрхийн ахиц дэвшлийг баталгаажуулах жендэрийн эрх тэгш байдлыг хангах, 16 дугаар зорилтын хүрээнд энх тайван, шударга ёсыг цогцлоох асуудлыг тусгасан ¹⁷ нь эмэгтэйчүүд болон энх тайвны асуудалд дэлхийн улс орнууд, олон улсын хамтын нийгэмлэг ач холбогдол өгч байгааг харуулж байна.

Нэгдсэн үндэсний байгууллага нь олон улсад энх тайван аюулгүй байдлыг хангах чиг үүрэг хамтын байгууллагын хувьд дайн, зэвсэгт мөргөлдөөн болж байгаа улс орнуудад энхийг сахиулах ажиллагааг явуулах асуудлыг чухалчилан авч үздэг билээ.

НҮБ-ын анхны энхийг сахиулах ажиллагаа нь 1948 оны Араб-Израйлийн дайн болон 1949 оны Энэтхэг-Пакистаны хил дагуух Жамму Кашмирын маргаан, тэдгээрийн хооронд байгуулсан гал зогсоох гэрээний хэрэгжилтийг хянах, сахиулахаар НҮБ-ын цэргийн ажиглагч нарыг илгээсэн байдаг ч түүнээс 9 жилийн дараа буюу 1957 онд анхны эмэгтэй энхийг сахиулагчид ажиллагаанд оролцож эхэлсэн бөгөөд 1957-1979 оны хооронд нийт 6250 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэсэнээс 5 нь эмэгтэйчүүд байсан байна. 1989 онд энэ тоо нь багахан эмэгтэй энхийг нэмэгдэж 20000 энхийг

¹⁷ <https://sdg.1212.mn/>

сахиулагчдын 20 нь эмэгтэй, 2000 онд энхийг сахиулагчдын нэг хувь ч хүрэхгүй байсан учраас НҮБ-аас эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч нэлээдгүй тандалтын ажил явуулж эмэгтэйчүүдийн оролцоог бий болгох нэмэгдүүлэх үндэслэлийг тодорхойлсон байдгаас дараах хэд хэдэн үндэслэлийг авч үзье. Үүнд:

Нэг. 1990-ээд онд Босни, Баруун Африк болон Урвандад болсон иргэний дайны үеэр хүмүүнлэгийн ажиллагаа явуулж байсан төрийн бус байгууллагууд ажиллагааны газар орон дээр эмэгтэйчүүдийн эрх илүүтэйгээр зөрчигдөж бэлгийн хүчирхийлэл, бие болон сэтгэл санааны дарамтад орж байгаа талаар мэдэгдэл хийж НҮБ-ын ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог энхийн болон аюулгүй байдлын салбарт нэмэгдүүлэх талаар санал, санаачилгуудыг гаргаж НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлд удаа дараа хүргүүлсэн;

Хоёр. 1995 онд Бээжинд зохион байгуулагдсан Дэлхийн эмэгтэйчүүдийн 4-р бага хурлаар эмэгтэйчүүдийг алагчлах бүхий л хэлбэрийг устгах тухай НҮБ-ын конвенцид үндэслэсэн батлагдсан Бээжингийн тунхаглалд “эмэгтэйчүүдийг жинхэнэ тэгш эрх болон эрх мэдлээр хангах” 23 зорилтыг биелүүлэхтэй холбоотой ядуурал, боловсрол, эрүүл мэнд, хүчирхийлэл, эдийн засаг, эрх мэдэл, шийдвэр гаргах, төрийн институцийн механизм, хүний эрх, хэвлэл мэдээлэл, байгаль орчин, охин-хүүхэд гэсэн заалтуудаас гадна зэвсэгт мөргөлдөөнд эмэгтэйчүүдийн хүч хэрэглэхгүй байх зарчмын дагуу дэлхийн оролцоог хангах талаар тусгаж "... хүч хэрэглэхгүй энх тайвныг сахин хамгаалах, хүний эрх, ардчилал, маргааныг энхийн замаар шийдвэрлэхэд НҮБ-ын уриалгын дагуу эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь чухал" талаар онцолсон зэрэг нь НҮБ-ыг энэ чиглэлд анхаарал илүүтэй хандуулахад хүргэсэн;

Гурав. 1999 онд НҮБ-ын нарийн бичгийн дарга асан Кофи Аннан энхийг сахиулах ажиллагааны явц, үр дүнд үнэлэлт, дүгнэлт өгөх цаашид баримтлах бодлогыг тодорхойлох зорилгоор "Хараат бус бие даасан ажлыг хэсэг"-ийг томилон ажиллуулсан. Энэ ажлын хэсгийн илтгэлд 1995 оноос өмнөх энхийг сахиулах ажиллагаа сэргөлдөгч талуудын зэвсэгт мөргөлдөөнийг хянадаг байсан бол 1995 оноос хойших ажиллагаа бол зэвсэгт мөргөлдөөнийг хянах болон зогсоох үүрэгтэйгээр явагддаг болсон нь энхийг сахиулах гэхээсээ илүүтэй энхийг бүтээн байгуулах чиглэлтэй болсон нь НҮБ энхийн ажиллагаанд оролцох бодлогоо боловсронгуй болгох шаардлагатайг харуулж байна гэсэн саналыг дэвшүүлээд Босни Херцеговина, Хайти, Сьерра Леон зэрэг улс орнуудад үүрэг гүйцэтгэж байсан энхийг сахиулагчдаас тухайн улсын төр засгийг бүтээн босгох, хууль тогтоох болон аюулгүй байдлыг хангах салбарт шинэчлэл хийхэд дэмжлэг туслалцаа үзүүлж өгөхийг хүссэн. Иймд энэ чиглэлд

орон нутгийн иргэдтэй илүү ойр ажиллаж чадах НҮБ-ийн хүний нөөцийн бодлогод эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар санал дэвшүүлсэн¹⁸;

Дөрөв. 2000 онд "Хараат бус бие даасан ажлыг хэсэг"-ийг дахин НҮБ-ын хээрийн ажиллагаануудад үнэлгээ хийн "Брахимын илтгэл"-ийг гаргасан байдаг. Уг илтгэлд олон талт энхийг сахиулах ажиллагааг хөгжүүлэх шаардлага байгааг хэд хэдэн үндэслэлээр тодорхойлсон байдаг. Тухайлбал орчин үед болж байгаа зэвсэгт мөргөлдөөнд НҮБ хэрхэн хүний аюулгүй байдлыг хангах, энгийн иргэдийг хамгаалахад гүйцэтгэх үүрэг, тухайн ажиллагааны газар оронд тухайн улсын хууль ёсны засаг захиргааны нэгжийг бий болгох, мөн түүнчлэн орон нутагт нь бие даасан хууль ёсны засаг захиргааны нэгжийг бий болгоход дэмжлэг үзүүлэхэд энхийг сахиулах үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатайг илтгээд зэвсэгт мөргөлдөөний үед илүү их хохирогч болж байгаа эмэгтэйчүүд, хүүхдүүд, энгийн иргэдийг хамгаалахад эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлсон;

Тав. НҮБ-ын ажиллагааны чиглэлээр судалгаа хийдэг институт судлаачид ажиллагааны газар оронд нэлээдгүй судалгаа явуулж эмэгтэй энхийг сахиулагч нарын ажиллагаанд үүрэг гүйцэтгэх давуу талыг тодорхойлж гаргасан байна. Үүнд:


- Энгийн иргэдийг хамгаалах, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг хамгаалах тал дээр илүү үр дүнтэй байдаг;
- Хурцадмал байдлыг намжаах, зөөлөн, эвлэрэлийг хурдан авчирч чаддаг;
- Бэлгийн хүчирхийлэлд өртсөн хохирогчдод илүү сайн тусламж үзүүлж чаддаг
- Шалган нэвтрүүлэх цэг дээр орон нутгийн эмэгтэйчүүдийг нэвтрүүлэхэд нэгжлэг хийх боломжтой;
- Хүчирхийлэлд өртсөн охид эмэгтэйчүүдтэй харьцаж сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх бүрэн боломжтой байдаг;
- Орон нутгийн иргэдтэй харилцаа тогтоох, улмаар тагнуулын мэдээлэл цуглуулах тал дээр илүү сайн ажилладаг;
- Орон нутгийн эмэгтэйчүүдэд ялангуяа охидуудад үлгэр дуурайл болж эмэгтэйчүүд хүчирхэг байж болно гэдгийг биеэрээ үлгэрлэж чаддаг гэж үзэж байна.

¹⁸ Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 35 ISBN 978-3-319-99105-4.

Эдгээр үндэслэлүүдтэй холбоотойгоор эмэгтэйчүүдийн оролцоог нь зэвсэгт мөргөлдөөнийг зохицуулах, энхийг сахиулах үйл ажиллагаанд бий болгох, нэмэгдүүлэх нь энх тайван, аюулгүй байдлыг хангахад чухал гэж үзээд санал, зөвлөмжийг боловсруулж холбогдох улс орон, байгууллага, нэгжүүдэд хүргүүлж байснаар НҮБ-аас энхийг сахиулах эмэгтэйчүүдийн оролцоог хангах талаар бодлогын баримт бичгүүдийг гаргаж эхэлсэн байна. Тухайлбал, 2000 онд баталсан НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн 1325 дугаар тогтоолоос¹⁹ эхлээд 2020 оны 2538 дугаар тогтоол хүртэл нийт 11 тогтоолыг баталсан байна. Эдгээр тогтоолыг хамтад нь эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын талаарх бодлогын баримт бичгүүд гэж үздэг. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын талаарх бодлогын баримт бичгүүдийг 1 дүгээр зургаар харуулав

1 дүгээр зураг. Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын талаарх бодлогын баримт бичгүүд

Эдгээр баримт бичигт зэвсэгт мөргөлдөөний үед эмэгтэйчүүд, охидын эрхийг хамгаалах, тэднийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, энх тайван, аюулгүй байдлын асуудалд эмэгтэйчүүдийн бодит оролцоог хангах



¹⁹ "Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт: дэг журам, механизм, практик". Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2003. №5.

талаар улс орнууд дотооддоо болон олон улсын түвшинд хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааг тодорхойлсон байдаг.

Дээрхи баримт бичгүүдээс хамгийн анхны баримт бичгийг онцолбол 2000 онд НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 тоот тогтоол (UNSCR 1325) батлагдсанаар эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын салбарт байр сууриа олоход түлхэц болсон тогтоол анх удаа гарсан бөгөөд энэ нь бусад баримт бичгүүдийн үндсэн суурь нь болдог.

Уг тогтоолд улс орнууд зэвсэгт мөргөлдөөний үед иргэдээ хамгаалах үүрэгтэй бөгөөд цэргийн ажиллагааг төлөвлөх, явуулахдаа энгийн иргэдийг хамгаалах, жендэрийн асуудлыг тактикийн болон стратегийн бүх түвшинд орхигдуулах ёсгүйг тодотгоод улс орнууд Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын асуудлаар дараах 4 чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг уриалсан. Үүнд:

1. Эмэгтэйчүүдийн оролцоог хангах эмэгтэйчүүдийг үндэсний болон орон нутаг, бүс нутаг, олон улсын түвшний энх тайван, улс төр, аюулгүй байдлын шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрэгтэйчүүдтэй адил тэгш оролцуулах;
2. Эмэгтэйчүүдийн эрх зөрчигдөхөөс хамгаалах зөрчил, мөргөлдөөний үед охид эмэгтэйчүүд хүчирхийлэлд өртөхгүй байх нөхцлийг бүрдүүлэх;
3. Эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх охид, эмэгтэйчүүдийн эсрэг чиглэсэн бүх төрлийн хүчирхийллийн хэлбэрээс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлагаас зугтах үзэгдэлтэй тэмцэх, зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийг оролцуулах;
4. Зөрчил, мөргөлдөөний дараах сэргээн босгох үйл ажиллагаа-эмэгтэйчүүд, охидын хүмүүнлэгийн "тусгай" хэрэгцээг хангах, тусламж үзүүлэх, нөхөн сэргээх үйл явцад манлайлах эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зэрэг болно.

НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн 1325 тоот "Эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдал" тогтоолын хэрэгжилтийг хангахын тулд НҮБ-ын Энхийн ажиллагааны газраас "НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх тухай уриалга гаргахаас гадна албан даалгаваруудыг хүргүүлсээр байна. Гэсэн хэдий ч эмэгтэй энхийг сахиулагчдын оролцоо хангалтгүй байна. Тухайлбал, 1957-1979 оны хооронд нийт 6250 энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэснээс 5 нь эмэгтэй, 1989 онд 20000 энхийг сахиулагчдын 20 нь эмэгтэй байсан бол 2022 онд 5765 эмэгтэй цэргийн

алба хаагчид үүрэг гүйцэтгээд байгаа нь нийт цэрэг, цагдаагийн албан хаагчдын 7,8 хувийг эзлээд байна.

Дүгнэлт

Нэгдсэн үндэсний байгууллагаас 2000 – 2020 оны хооронд 11 тогтоолыг баталсан байдаг бөгөөд эдгээр тогтоолыг хамтад нь эмэгтэйчүүд, энх тайван, аюулгүй байдлын талаарх бодлогын баримт бичгүүд гэж үздэг. Эдгээр бодлогын баримт бичгүүдэд жендэрийн эрх тэгш байдлыг хангах эмэгтэйчүүдийг хүчирхийлэх, хүний хулгай наймаанд өртөх, бэлгийн болон бусад хэлбэрээр дарлан мөлжих, ялгаварлан гадуурхах явдлыг таслан зогсоох, шийдвэр гаргах бүх түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх, зэргийг голчлон үзсэн байна.

Мөн энхийн ажиллагааны газраас НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй эмэгтэй цэргийн алба хаагчдын тоог нэмэгдүүлэх тухай уриалга гаргасан нь үр дүнгээ өгч 2022 онд 5765 эмэгтэй цэргийн алба хаагчид үүрэг гүйцэтгээд байгаа нь харагдаж байна. Гэсэн хэдий ч эмэгтэй энхийг сахиулагчдын оролцоо хангалтгүй, нэмэгдүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна.

Эх сурвалж:

1. Википедия (Нэгдсэн үндэсний байгууллага)
2. НҮБ – ийн тогтвортой хөгжлийн зорилго
3. "Аюулаас хамгаалах салбарт тавих парламентын хяналт: дэг журам, механизм, практик". Парламентын гишүүдэд зориулсан гарын авлага. УБ., 2003. No5.
4. Cedric de Coning, Mateja Peter, United Nations Peace Operations in Changing Global Order, Springer Nature Switzerland AG, 2019. 35 ISBN 978-3-319-99105-4.